



ГАРАА УГААЯ



МАСКАА ЗҮҮЕ



ЗАЙГАА БАРЬЯ



MILLENNIUM  
CHALLENGE CORPORATION  
UNITED STATES OF AMERICA

# УСНЫ САЛБАРЫН ЭРГЭН ТОЙРОНД

Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№1 (8)

2020.12.14

## БҮХ АЙЛ ӨРХ, ЗАРИМ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЦАХИЛГААН, ДУЛААН, УС, ХОГНЫ ТӨЛБӨРИЙГ ТӨР ТӨЛНӨ



Монгол Улсын Засгийн газар 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдөр ээлжит бусаар хуралдаж, цар тахлын хүнд үед иргэдийн амжиргааг дэмжих, аж ахуйн нэгжүүдэд ажлын байраа хадгалахад дэмжлэг болгох зорилгоор улсын хэмжээнд бүх айл өрх, 123 800 аж ахуйн нэгжийн цахилгаан, дулаан, ус, хогны төлбөрийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл төр бүрэн хариуцах шийдвэр гаргалаа. Мөн 100 м.кв-аас доош талбайтай орон сууцны айл өрхийн дулааны төлбөрийг мөн тэглэхээр болжээ. Өөрөөр хэлбэл, 120 м.кв талбайтай байранд амьдардаг айл өрх 20 м.кв талбайд ногдох дулааны төлбөрөө төлөх юм байна. Харин төсөвт байгууллага,

төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээд, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, банк, банк бус санхүүгийн байгууллага, крипто валюттай холбогдох үйл ажиллагаа эрхлэгч, газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч, интернэт, үүрэн холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч, согтууруулах ундаа, тамхи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч болон өнгөт металл болон хар төмөрлөг, цементийн үйлдвэр төлбөрөөс чөлөөлөгдөхгүй.

[Эх сурвалж: https://zasaq.mn/](https://zasaq.mn/)

## СУДАЛГАА: 2040 ОН ГЭХЭД 18-ААС ДООШ НАСНЫ ДӨРВӨН ХҮҮХЭД ТУТМЫН НЭГ НЬ БУЮУ 600 САЯ ОРЧИМ ХҮҮХЭД УСНЫ ХЭТ ХОМСДОЛТОЙ НУТАГТ АМЬДАРНА



2040 он гэхэд дэлхий даяар 18-аас доош насны дөрвөн хүүхэд тутмын нэг нь буюу 600 сая орчим хүүхэд усны хэт хомсдолтой нутагт амьдарна" гэсэн судалгааг НҮБ-ын Хүүхдийн сангаас гаргажээ. Ирээдүй хойч үед маань үлдэх усны нөөц хүмүүс бидний хэрхэн зөв зүйтэй ашиглахаас шууд хамаарна. Зориг Сан, Австралийн Засгийн газартай хамтран хэрэгжүүлдэг "Эмэгтэйчүүдийн манлайлал" хөтөлбөрийн хүрээнд Австрали улсад магистрын зэрэг хамгаалсан таван бүсгүй нийгэмд усны зөв зохистой хэрэглээний талаар мэдлэг олгох, усаа хайрлаж, гамнадаг залуу үеийг бий болгоход хувь нэмрээ оруулахаар "Save future by drop" буюу "Ирээдүйгээ дуслар аварья" олон

нийтийн хөгжлийн төслийг хэрэгжүүлж эхэлжээ. Найман сарын хугацаанд үргэлжлэх хөтөлбөрт "Оюуны Ундраа" сургуулийн 3-5 дугаар ангийн 30 сурагчийг хамруулан, зөвхөн усны зөв хэрэглээний талаар бус, ирээдүйн манлайлагчдыг бэлтгэх тусгай хөтөлбөр боловсруулжээ. Цаг үеийн байдлаас улбаалан хичээлүүдээ цахим хэлбэрт оруулан өөрчилж, долоо хоног бүрийн бямба гарагт 18:00-20:00 цагийн хооронд сонгосон 30 сурагч, тэдний эцэг эхэд цахим сургалтаа явуулж байна.

[Эх сурвалж: https://www.gogo.mn/](https://www.gogo.mn/)

## УСНЫ ГАЗРААС 21 САВ ГАЗРЫН ЗАХИРГААДТАЙ ЦАХИМ ХУРАЛ ХИЙЛЭЭ



Усны газраас 21 сав газрын захиргаатай хамтран 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдөр цахим хурлыг зохион байгуулжээ. Хурлаар Усны газрын хэрэгжүүлсэн томоохон ажлууд, 2020-2024 хийх ажлын төлөвлөгөө, сав газрын захиргаадын хүний нөөцийн асуудал, 2020 оны жилийн санхүүгийн тайлан баланс ирүүлэх тухай, Төрийн үйлчилгээг цахимжуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө болон "Цэнхэр алт усаа хайрлая" аяны үр дүнг танилцуулсан байна.

[Эх сурвалж: Усны газар фэйсбүүк хуудас](#)

## ТУУЛ ГОЛЫГ ХАМГААЛАХ, БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ЦАХИМААР СОНСОВ



Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Туул голын сав газраас түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоож, нөхөн сэргээлт хийж, усны төвшнийг нэмэгдүүлэх бодлогыг тусгасан. Энэ хүрээнд төлөвлөгөөт ажлууд хэвийн үргэлжилж байгаа тухай Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас мэдээллээ. Эх сурвалжийн мэдээлснээр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Удирдлагын зөвлөл 2020 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Туул голыг хамгаалах, бохирдлыг бууруулах чиглэлээр 2021-2022 онд хийж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг цахимаар сонсчээ.

[Эх сурвалж: https://www.mne.mn/](https://www.mne.mn/)

## ТОМИЛГОО

### АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР УСНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТНҮҮДТЭЙ БОЛЖЭЭ

Ашигт малтмал, газрын тосны газрын гурван гол хэлтэс усны асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй болсон байна. Тодруулбал, Хүнд үйлдвэр, судалгаа, техник, технологийн хэлтсийн мэргэжилтэн Х.Анар, Нүүрс судалгааны хэлтсийн мэргэжилтэн Б.Алтсүх болон Уул уурхайн судалгааны хэлтсийн мэргэжилтэн Х.Лхагвабаатар нар усны асуудал хариуцан ажиллахаар болжээ.

[Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар](#)